

Ёс зүй, соён гэгээрүүлэх ажиллагаа ба ёс зүйн хариуцлага хүлээлгэх эрх зүйн зохицуулалт анхаарах асуудал

Илтгэгч: Хүний эрхийн Үндэсний
Комиссын дарга, доктор, профессор
Д.Сүнжид

2026.06.15



АГУУЛГА

01

Хүний эрх ба төрийн үүрэг/хүний эрхийн төрийн тогтолцоо

02

Ёс зүйн соён гэгээрүүлэх ажиллагаа ба хүний эрхийн боловсрол

03

Ёс зүйн хариуцлага хүлээлгэхэд хүний эрхийг хангах нь

Төрийн хүний эрхийн үүрэг

Хүний эрхийн
хэм хэмжээг
сахин
биелүүлэх
үүрэг (obligation
to respect)

Хүний эрхийг
хамгаалах
үүрэг (obligation
to protect)

Хүний эрхийг
хангах үүрэг
(obligation to
fulfill)

Зөрчигдсөн
эрхийг сэргээх
үүрэг (obligation
to ensure
effective
remedies)

“The obligations of the Covenant are binding on all branches of government (legislative, executive and judicial), and other public or government authorities.”

Human Rights Committee, General Comment No 21, para 4

Хүний эрхийн үүргийг (хэм хэмжээг) сахин биелүүлэх үүрэг



Төрийн байгууллага хүний эрхийг зөрчихгүй (**ХЭХ, ЕТЗ1(6)**)

- Хууль тогтоох байгууллага хүний эрхийг үндэслэлгүйгээр, хэтрүүлэн хязгаарласан хууль батлахгүй байх;
- Гүйцэтгэх эрх мэдэл хүний эрхийг зөрчих бодлогын шийдвэр гаргахгүй байх;
- Шүүх хүний эрхийн хэм хэмжээг зөрчсөн байдлаар хуулийг тайлбарлаж хэрэглэхгүй байх;
- Төрийн байгууллагууд хүний эрхийг зөрчсөн үйл ажиллагаа явуулахгүй байх;

Хүний эрхийг хангах үүрэг

 Хүний эрхийг бодитой эдлэх нөхцлийг бүрдүүлнэ (**ЭЗНСЭХ, ЕТ 24(7-10)**)

- Шаардлагатай байгууллага, бүтцийг бий болгох, хангалттай төсөв хувиарлах, бодлого, хөтөлбөрийг гаргах, байгууллагуудын уялдаа холбоог хангах. Энэ хүрээнд хууль тогтоогч шаардлагатай хууль тогтоомжийг батлах, төсвийг хувиарлах, гүйцэтгэх засаглал төлөвлөх, хэрэгжүүлэх, ХЭҮБ (ХЭҮК) эдгээр арга хэмжээний үр дүн, үр нөлөөг хянах үүрэгтэй.

Хүний эрхийг хамгаалах үүрэг

 Гуравдагч этгээд хүний эрх зөрчихөөс хамгаалах (**ХЭХ, ЕТ31(8), ЭЗНСЭХ, ЕТ 24(14-16))**

- Хувь хүн, хувийн хэвшлийн байгууллага, бусад гуравдагч этгээдийн үйл ажиллагааг зохицуулах;
- Хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх;
- Хүний эрхийн зөрчлийг шалгаж, шийдвэрлэх

 Энэ үүргийг **шүүх** дангаар хэрэгжүүлэх боломжгүй учраас захиргааны байгууллагуудын хянан шийдвэрлэх ажиллагаа, хүний эрхийн үндэсний байгууллагын гомдол шийдвэрлэх чиг үүрэг оролцдог.

Зөрчигдсөн эрхийг сэргээх үүрэг

 Шүүхийн болон шүүхийн бус арга замаар зөрчигдсөн эрхийг үр дүнтэй сэргээнэ (ИБУТЭОУП-ын 2 дугаар зүйл 3, **ХЭХ, ЕТ31(15-16)**)

- Хараат бус шүүх хэрэг, маргааныг шийдвэрлэх (үндсэн механизм);
- Зөрчигдсөн эрхийг сэргээх шүүхийн бус механизм ажиллах;
- Зөрчигдсөн эрхийг хараат бусаар (independent), үр дүнтэй (effective), хүнд ойр дөт байдлаар (accessible), шуурхай (timely) шийдвэрлэх нөхцлийг хангах нь олон улсын эрх зүйн шаардлага юм.

Хүний эрхийн үндэсний тогтолцоо

“Human rights system must
be multi-institutional”
(ЭЗНСЭХ, ЕТ 24(14-16))

Хууль тогтоох

УИХ

Бодлогын хэрэгжилтийг зохион
байгуулах

Засгийн газар, яамд

Хүний эрхийг хамгаалах,
зөрчигдсөн эрхийг сэргээх

Шүүх, шүүхийн бус маргаан
шийдвэрлэх механизмууд (ХЭҮК,
захиргааны байгууллагууд)

Захиргааны шийдвэр гаргах,
салбарыг зохицуулах

Төрийн захиргааны
байгууллагууд (салбарын
зохицуулах байгууллагууд)

Үүргийн хэрэгжилтэд хяналт
тавих, тогтолцоог сайжруулахад
дэмжлэг үзүүлэх, хүний эрхийн
зөрчлөөс урьдчилан сэргийлэх

ХЭҮК

Монгол Улсын эрх зүй

1. Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.


(Монгол Улсын Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 1)

5.1. Монгол Улсад хүний эрхийг хамгаалах үндэсний тогтолцоо нь Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, шүүх, прокурор, Үндсэн хуулийн цэц, төрийн болон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, Хүний эрхийн Үндэсний Комиссоос бүрдэнэ.

5.2. Монгол Улсад хүний эрхийг хамгаалах үйл ажиллагаанд иргэний нийгмийн байгууллагыг оролцуулж болно.

(Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 5 дугаар зүйл)

ХҮНИЙ ЭРХИЙГ ХАМГААЛАХ ҮНДЭСНИЙ ТОГТОЛЦОО




Хүний эрхийн үндэсний байгууллага

Хүний эрхийн үндэсний байгууллага гэж юу вэ? (ПЗ А.1-А.3)

- Хараат бус төрийн (захиргааны) байгууллага
- Тогтолцоог хянах үндсэн чиг үүрэгтэй байгууллага (system-level oversight body)
- Урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх, зөвлөн туслах мөн чанартай механизм (preventive and advisory mechanism)

Хүний эрхийн үндэсний байгууллага юу биш вэ?

- Шүүх эрх мэдлийн байгууллага биш
- Гүйцэтгэх эрх мэдлийн (executive agency) байгууллага биш
- НҮБ-ын эсхүл иргэний нийгмийн байгууллага биш



Ёс зүйн соён гэгээрүүлэх ажиллагаа



Ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлэх үндсэн арга зам

- ✓ Мэргэшсэн төрийн албыг бэхжүүлэх
- ✓ Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх
- ✓ Хариуцлагын тогтолцооны үр нөлөөг нэмэгдүүлэх
- ✓ Авлигын эсрэг арга хэмжээг хэрэгжүүлэх
- ✓ Иргэдийн оролцоо, хяналтыг дэмжих



Соён гэгээрүүлэх ажиллагааны эрх зүйн үндэс



ҮНДСЭН ХУУЛИЙН 16 ДУГААР ЗҮЙЛ:

- Хүн бүр сурч, боловсрох эрхийг баталгаажуулсан.



ХОЛБОГДОХ ХУУЛЬ ТОГТООМЖ

- Төрийн албаны тухай хууль
- Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль
- Авлигын эсрэг хууль
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль
- Бусад хууль тогтоомж

ЁС ЗҮЙН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, СОЁН ГЭГЭЭРҮҮЛЭХ АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД:

1

СУДЛАХ

Зөрчлийн шалтгаан, нөхцөлийг тогтоох



2

МЭДЭЭЛЭХ

Олон нийтэд мэдээлэл түгээх



3

СУРГАХ

Сургалт, нөлөөллийн ажил зохион байгуулах



4

ЗӨВЛӨХ

Арга зүйн зөвлөгөө өгөх



5

ХЭРЭГЖҮҮЛЭХ

Урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх



Улсын Их Хурлын 2024 оны 27 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх үндэсний хөтөлбөр” /2024-2030 он/-ийг баталж, үндэсний түвшин нэгдсэн бодлого чиглэлтэй болсон. Тус хөтөлбөрт хүний эрхийг дээдэлсэн хандлага, соёлыг төлөвшүүлэх талаар тусгасан бөгөөд Ёс зүйн хорооноос 2024 онд баталсан төрийн албан хаагчийн сургалтын хөтөлбөрийн агуулгад хүний эрхийн сургалтыг оруулснаар төрийн албан хаагч бүр хүний эрхийн мэдлэг, ойлголтоо дээшлүүлж, албан үүргээ хэрэгжүүлэхдээ хүний эрхэд суурилсан хандлагыг төлөвшүүлэх чухал нөхцөл болсон.

Төрийн албан хаагч нь:



- ✓ Иргэдэд үнэн зөв мэдээлэл өгөх
- ✓ Эрх, үүргийг тайлбарлах
- ✓ Хууль тогтоомжийг сурталчлах
- ✓ Нээлттэй, ойлгомжтой харилцах үүрэгтэй.

Соён гэгээрүүлэх ажлын гол цөм нь:



- ✓ хууль эрх зүйн мэдлэг,
- ✓ хүний эрхийн боловсрол,
- ✓ төрийн үйлчилгээний талаарх ойлголтыг нэмэгдүүлэх үйл ажиллагаа юм.

ХҮНИЙ ЭРХИЙН БОЛОВСРОЛЫГ ДЭМЖИХ ЧИГ ҮҮРГИЙН ХҮРЭЭНД КОМИСС 2001-2025 ОНД



4848

Сургалт



13579

Цаг



269401

Оролцогч



1236

Сургагч багш

Хүний эрх ба ёс зүйн зөрчлийн уялдаа

Ёс зүйн зөрчил нь хүний эрхийг хөнддөг ба дараах хүний эрхийн суурь 6 зарчимд нийцдэггүй үйлдэл, эс үйлдэхүй юм.

1

ХАРИЛЦАА, ХАНДЛАГАТАЙ ХОЛБООТОЙ

ЖИШЭЭ:

- Хүний нэр төр, алдар хүндэд халдсан үг хэллэг хэрэглэх, үйлдэл гаргах;
- Иргэн, албан хаагчийн санал, хүсэлт, өргөдөл, гомдлыг үл тоомсорлох, хариу өгөхгүй байх;
- Төрийн үйлчилгээ үзүүлэхдээ хүнд суртал гаргах, иргэнийг чирэгдүүлэх

ХОЛБОГДОХ ХҮНИЙ ЭРХИЙН АСУУДАЛ:

- Хүний нэр төр, алдар хүнд, эрхэм чанар;
- Өргөдөл гомдол гаргах, шийдвэрлүүлэх, хариу авах эрх
- Иргэн төрийн үйлчилгээг хуульд заасан хугацаа, журмын дагуу авах эрх

2

ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЛТ БА ТЭГШ ЭРХТЭЙ ХОЛБООТОЙ

ЖИШЭЭ:

- Үйлчилгээ үзүүлэхдээ, мэдээлэл өгөхдөө ялгавартай хандах;
- Үйлчлүүлэгч, иргэдийн хэрэгцээ, онцлог нөхцөлийг харгалзан үзэхгүй байх.

ХОЛБОГДОХ ХҮНИЙ ЭРХИЙН АСУУДАЛ:

- Ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрх
- Хууль, шүүхийн өмнө эрх тэгш байдал
- Нийгмийн оролцоо, хүртээмж

3

ШУДАРГА ЁС, ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХТАЙ ХОЛБООТОЙ

ЖИШЭЭ:

- Хувийн ашиг сонирхлоо албан үүргээс дээгүүр тавих;
- Хамаарал бүхий этгээдэд давуу байдал олгох;
- Шийдвэр гаргахдаа тал засах, алагчлах;

ХОЛБОГДОХ ХҮНИЙ ЭРХИЙН АСУУДАЛ:

- Шударга ёс;
- Тэгш байдал;
- Хууль дээдлэх зарчим;

4

МЭДЭЭЛЭЛТЭЙ ХОЛБООТОЙ

ЖИШЭЭ:

- Худал мэдээлэл тараах
- Албаны чиг үүрэгтэй холбоотой мэдээллийг санаатайгаар нуун дарагдуулах

ХОЛБОГДОХ ХҮНИЙ ЭРХИЙН ЗАРЧИМ:

- Халдашгүй байх эрх -Хүний хувийн мэдээллээ хамгаалуулах эрх;
- Аюулгүй байх эрх;
- Мэдэх эрх

25 жилийн хугацаанд хүний эрх, эрх чөлөө,
зөрчигдсөн эрхийг сэргээлгэхээр иргэдээс



2025 он

ГОМДОЛ МЭДЭЭЛЭЛ
нийт орон нутгаас

1344 288



Сүүлийн **5** жилд **4425** гомдол, мэдээлэл хүлээн авч шийдвэрлэсэн нь нийт Комисст ирүүлсэн гомдол, мэдээллийн **37 хувийг** эзэлж байна.



2020 онд шинэчлэн батлагдсанаас хойш Комисст хандсан иргэдийн гомдол мэдээллийн тоо **70,1 хувиар** өссөн үзүүлэлттэй байна.

Ирсэн гомдлын эрхийн төрөл

№	Гомдлын эрхийн төрөл	Гомдлын тоо	Гомдлын эрхийн төрөл	Гомдлын тоо
1	Шударгаар шүүлгэх эрх	453	Чөлөөтэй зорчих эрх	26
2	Хөдөлмөрлөх эрх	284	Жендэрийн эрх тэгш байдал	16
3	Халдашгүй чөлөөтэй байх эрх	160	Амьдралын хүрэлцээтэй түвшинд аж төрөх эрх	15
4	Төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл гомдол гаргах эрх	73	Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх	12
5	Хүүхдийн эрх	64	Мэдээлэл хайх, хүлээн авах эрх	11
6	Нийгмийн халамж хүртэх эрх	35	Шашин шүтэх, эс шүтэх эрх	9
7	Хөдлөх, үл хөдлөх эд хөрөнгө шударгаар олж авах эрх	34	Эвлэлдэн нэгдэх эрх	7
8	Эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх	33	Амьд явах эрх	5
9	Эрүүл мэндээ хамгаалуулах эрх	31	Сонгох, сонгогдох эрх	3
10	Ялгаварлан гадуурхалтаас ангид байх эрх	31	Иргэний харьяалалтай байх эрх	2
11	Сурч боловсрох эрх	28	Тодорхойгүй	10
Нийт				1344

Иргэний Үндсэн хууль, олон улсын гэрээ, конвенцоор баталгаажуулсан дараах эрхийг зөрсөн үндэслэлээр хариуцлага тооцох саналыг хүргүүлсэн байна.

№	Эрхийн зөрчил	2021	2022	2023	2024	2025	Бүгд
1	Ажлын байрны дарамт, хүчирхийлэл	4	4	7	9	10	34
2	Халдашгүй, чөлөөтэй байх эрх	2	3	1	2	2	10
3	Хүүхдийн эрх	1	1	-	3	4	9
4	Хувийн нууцаа хамгаалуулах эрх	3	-	1	-	1	5
5	Хүнлэг бус харьцаанаас ангид байх эрх	1	-	-	-	2	3
6	Сурч боловсрох эрх	-	-	1	-	2	3
7	Нийгмийн халамж хүртэх эрх	1	-	-	-	-	1
8	Ахмадын эрх	-	-	-	1	-	1
9	Хууль зүйн туслалцаа авах эрх	-	-	-	1	-	1
10	Шударга шүүхээр шүүлгэх эрх	-	-	-	1	-	1
11	Өргөдөл, гомдол гаргах эрх	-	-	-	-	1	1
12	Албадан хөдөлмөрөөс ангид байх	-	-	-	-	1	1
Бүгд		12	8	10	17	23	70

Шаардлага, зөвлөмжийн мөрөөр хариуцлага хүлээсэн хэлбэр дараах байдалтай байна.

№	Хариуцлага	2021	2022	2023	2024	2025	Бүгд
1	Сануулах	11	4	7	8	10	40
2	Цалингийн хувь бууруулах	1	1	4	3	7	16
3	Ажлаас халах	3	1	1	3	3	11
4	Ёс зүйн хариуцлага хүлээлгэх	1	-	-	-	1	2
5	Захиргааны шийдвэрээр торгох	-	-	-	1		1
Бүгд		16	6	12	15	21	70

Хариуцлага хүлээсэн албан тушаалтан:

№	Албан тушаалтан	2021	2022	2023	2024	2025	Бүгд
1	Удирдах албан тушаалтан	5	2	6	7	9	29
2	Гүйцэтгэх албан тушаалтан	11	4	6	8	12	41
Бүгд		16	6	12	15	21	70

Ёс зүйн зөрчлийг шалгаж шийдвэрлэхэд анхаарах асуудал

1



ШУДАРГА АЖИЛЛАГААГААР ХАНГАГДАХ ЭРХ

Ёс зүйн зөрчил шалгах ажиллагаа нь шударга, хараат бус, ил тод байх ёстой.

- Тайлбар гаргах боломж олгох;
- Нотлох баримттай танилцах;
- Өөрийгөө өмгөөлөх;
- Шийдвэрийг давж заалдах эрхийг хангах зэрэг орно.

2



НЭР ТӨР, АЛДАР ХҮНДЭЭ ХАМГААЛУУЛАХ ЭРХ

Ёс зүйн зөрчилтэй холбоотой асуудлыг шийдвэрлэхдээ тухайн албан хаагчийг урьдчилан буруутай гэж үзэхгүй байх, баталгаагүй мэдээллийг олон нийтэд түгээхгүй байх шаардлагатай.

Хэрэв шалгалтын явцад нэр төрд нь халдсан бол хүний эрхийн зөрчил үүсэх эрсдэлтэй.

3



ХУВИЙН НУУЦ БА МЭДЭЭЛЭЛ ХАМГААЛУУЛАХ ЭРХ

Ёс зүйн хяналт шалгалтын явцад цуглуулсан мэдээллийг зөвхөн хуульд заасан зорилгоор ашиглах ёстой.

- Хувийн мэдээллийг зөвшөөрөлгүй тараахгүй байх;
- Нууцлалын шаардлагыг хангах хэрэгтэй.

4



ҮЗЭЛ БОДЛОО ИЛЭРХИЙЛЭХ ЭРХ

Төрийн албан хаагч нь иргэний хувьд үзэл бодлоо илэрхийлэх эрхтэй боловч төрийн албаны төвийг сахих зарчимтай зохицон хэрэгжих ёстой.

Иймд үзэл бодлоо илэрхийлсний төлөө бус, харин төрийн албаны ёс зүйн бодит зөрчил гаргасан тохиолдолд л хариуцлага хүлээлгэх нь хүний эрхийн шаардлагад нийцнэ.

Ёс зүйн хариуцлага хүлээлгэхэд анхаарах асуудал

2. Пропорциональ байх зарчим

Зөрчлийн шинж, хор уршигтай нь тохирсон арга хэмжээ авах



4. Ил тод, үндэслэлтэй байх зарчим

Шийдвэр нь нотлох баримтад тулгуурласан, ойлгомжтой үндэслэлтэй байх.



1. Хууль ёсны байх зарчим

Зөвхөн хуульд заасан үндэслэлээр хариуцлага ногдуулах.



3. Ялгаварлан гадуурхахгүй байх зарчим

Ижил төрлийн зөрчилд ижил хариуцлага ногдуулах



5. Хараат бус байх зарчим

Ёс зүйн асуудлыг улс төрийн болон хувийн ашиг сонирхлын нөлөөллөөс ангид шийдвэрлэх.



Гомдол гаргагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахад анхаарах асуудал

- Үзэл бодлоо илэрхийлэх эрх
- Төрийн байгууллагад өргөдөл, гомдол гаргах эрх
- Хууль өмнө эрх тэгш байх эрх
- Хувийн нууцын халдашгүй байдлын эрх
- Үр дүнтэй эрх зүйн хамгаалалт авах эрх

Гомдол гаргагчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах нь хүний эрхийг бодитоор хангах үндсэн нөхцөл юм. Иймд гомдлыг шударга, ил тод, хараат бусаар шуурхай шийдвэрлэж, гомдол гаргагчийг аливаа дарамт, ялгаварлалтаас хамгаалан, эрх нь зөрчигдсөн тохиолдолд үр дүнтэй сэргээн хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлэх шаардлагатай.



САХИЛГЫН БОЛОН ЁС ЗҮЙН ХАРИУЦЛАГА



Сахилгын зөрчил

- Хөдөлмөрийн харилцааны хэм хэмжээний зөрчил,
- Алба хаших харилцааны хэм хэмжээний зөрчил



Ёс зүйн зөрчил

- Мэргэжлийн үнэт зүйл
- Алба хаших суурь нөхцөл, хандлага



Анхаарал хандуулсанд баярлалаа

Хүний эрх, эрх чөлөөг орон даяар, цаг ямагт, хүн бүрд

